Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,484,277.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 431,224.7 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | 0 |
| Авлага | 20,292.7 | 2,492.7 | -17,800.0 |
| Бараа материал | 239,211.2 | 298,832.5 | 59,621.3 |
| Үндсэн хөрөнгө | 4,311,640.1 | 4,945,983.7 | 634,343.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | -1,518,090.8 | -1,763,030.9 | -244,940.2 |
| **Нийт хөрөнгө** | **3,053,053.2** | **3,484,277.9** | 431,224.7 |
| Өр төлбөр | 251.3 | 1,206.7 | 955.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,052,801.9 | 3,483,071.2 | 430,269.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,053,053.2** | **3,484,277.9** | 431,224.7 |

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 298,832.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 135,457.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч сумын ОНХС-аас 137,900.9 мянга, аймгийн ЗДТГ-аас 12,062.1 мянга, зуд болсонтой болсонтой холбоотой хандив тусламжаар 119,448.0 мянган төгрөгийн эм боох материал, өвс тэжээл үнэ төлбөргүй авсан ба үйл ажиллагаандаа 345,246.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,945,983.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 70,546.0 мянга төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн ЗДТГ-аас 189,867.9 мянга, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 414,299.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч 40,370.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/67 дугаар тогтоолоор акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,484,277.9 мянган төгрөг болж 430,269.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 430,269.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 811,098.1 мянган тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 367,337.6 мянган төгрөгөөр өсгөж 1,178,435.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,278,135.7 мянган төгрөг болгож 99,700.0 мянган төгрөгөөр өсгөн баталсан нь төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,278,135.7 мянган төгрөг батлагдсанаас 1,242,593.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,242,593.1 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь орон нутгийн нөөц хөрөнгийг 20,333.3 мянган төгрөгийг дутуу зарцуулсан нь голлох нөлөө үзүүлсэн байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 үндсэн үйл ажиллагаа зардал | 904,189.60 | 895,281.76 | 8,907.84 | 99% |
| 2 | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 166,366.10 | 165,179.71 | 1,186.39 | 99% |
| 3 | 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж | 6,000.00 | 3,192.00 | 2,808.00 | 53% |
| 4 | 81102 орон нутгийн нөөц хөрөнгө | 143,500.00 | 123,166.70 | 20,333.30 | 86% |
| 5 | 81701 байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал | 52,672.00 | 50,672.97 | 1,999.03 | 96% |
| 6 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах | 5,408.00 | 5,100.00 | 308.00 | 94% |
| | Нийт дүн | 1,278,135.70 | 1,242,593.14 | 35,542.56 | 97% |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 8,907.8 мянга буюу 1 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 1,186.4 мянга буюу 1 хувь, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 2,808.0 мянга буюу 47 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 20,333.3 мянга буюу 14 хувь, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 1,999.0 мянга буюу 4 хувь, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардлаас 308.0 мянга буюу 6 хувь нийт 35,542.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 9 төрлийн 98,173.8 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* /мян.төг/

| Д/д | Орлогын нэр төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Заалны орлого | 7,614.3 |
| 2 | Хайгуулын барьцаа төлбөр | 6,819.6 |
| 3 | СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА хандив | 28,800.0 |
| 4 | Эрдэнэмонгол хандив | 2,500.0 |
| 5 | Нутгийн зөвлөлийн хандив | 10,920.0 |
| 6 | ОН-т тасралтгүй 5 жил ажилласан ТЗ албан хаагчдын урамшуулал | 28,112.4 |
| 7 | Статистик хэлтэс(мал тооллогын зардал) | 2,407.5 |
| 8 | СРМ 2862468 АВТОЗАМ ТӨСӨЛ БОМТ БАРЬ | 10,000.0 |
| 9 | БОАЖГ Мазаалай бахархалт өдөр шагналын зардал | 1,000.0 |
| | нийт орлогын дүн | 98,173.8 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх 98,173.8 мянган төгрөгийн орлогыг 74,293.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба оны эцэст 23,880.3 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугээр сарын 19-ний өдрийн 187 тоот албан бичиг ирүүлсэн.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ийн 1 дүгээр гарын үсгийг Л.Батбаяр, Г.Өлзийбат 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Доржсамбуу нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анх батлагдсан төсвийн нийт зардлын 1,178,435.7 мянган төгрөгөөс тооцоход 11,784.4 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 7,659.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага хувцас бомборын зардалд 4,187.7 мянган төгрөгийг төлсөн тул төлбөрийн акт тогтоосон.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,212,057.3 мянган төгрөгийн 13 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 284,762.3 мянган төгрөгийн 26 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны 12 сард эхний 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийж 192,546.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч аудитын явцад залруулж аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй 2,000.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 105,416.0 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 96,116.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага, 9,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн хүргүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 9,300.0 | 1 | 9,300.0 | 100 |
| Албан шаардлага | 4 | 96,116.0 | 4 | 96,116.0 | 100 |
| **Нийт дүн** | 5 | 105,416.0 | 5 | 105,416.0 | 100 |

Эх сурвалж: 2024 оны аудитын тайлангаас

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 263,986.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 7,187.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 256,798.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

1. Шинэжинст сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор "Шинэжинст суманд нэн шаардлагатай орон тоонд уригдан ирсэн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 46,500.0 мянган төгрөгийн урамшууллыг багш эмч нарт олгохоор баталж 41,850.0 мянган төгрөгийг олгож суутган тооцсон ХАОАТ-ын 2,650.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж 2,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь**: Суутган тооцсон 2,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй хээрийн дадлага сургалт явуулах тухай аймгийн Засаг даргын 2024.05.02-ны өдрийн А/271 дүгээр захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтын зардалд 2024.05.07-д иргэний дансанд 1,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ба анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Зориулалт бусаар зарцуулсан 1,000.0 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.Сумын Засаг даргын 2024.12.18-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага хувцас бомборын зардалд 4,187.7 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Зориулалт бусаар зарцуулсан 4,187.7 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн тайланд өглөгөөр бүртгээгүй байхад Дурсамж принт ХХК руу 2024 оны 05 сарын 27 өдөр 2021 онд үйлдвэрлэсэн “Өрхтэй харилцах дэвтрийн үнэ" 2,645.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6 дах “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Цаашид санхүүгийн тайланд тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өглөгийг барагдуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. 2024 оны 04 сарын 08-ны өдөр тээврийн хөлсөнд 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд Э баримтгүй хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.6 дахь" Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь:** Э баримт нөхөн мэдээлж зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын ЗДТГ-ын Ланд-200 автомашины урсгал засварын зардалд 2024.02.16-д иргэнд 17,000.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

4. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор баталгаажсан үүлдэр омгийн малын стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийн ялган төвлөрүүлэх, нийлүүлэх ажлын зардлыг санхүүжүүлэхэд 28,000.0 мянган төгрөг хуваарилагдсан байна. Дээрх хөрөнгийн тендерт Шинэжинст сумын Залаагийн цагаан сувд ХХК шалгаран шилэн сонгож, Шинэжинст сумын ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон комисс Баянбулаг омгийн 40 хуц, Залаажинст Эдрэн үүлдрийн 40 ухна хүлээн авсан байхад сумын ЗДТГ-ын хөрөнгөд орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийн заавал бүртгэнэ; 14.4.2 дахь "Бүх хөрөнгө,хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шилмэл омгийн 28,000.0 мянган төгрөгийн мал амьтадыг байгууллагын хөрөнгөд бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

5. Тусгай зориулалтын материалаас өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, байгууллагын даргын тушаал шийдвэр гараагүй байхад 36,216.7 мянган төгрөгийн хөрөнгө зарлагадсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх Тооллогын комисс дараах үүрэгтэйд 5) "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын хөрөнгийг дахин тоолж өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэр гаргах албан шаардлагыг хүргүүлэв.

6. Тайлан оны санхүүгийн тайланд 129,809.8 мянган төгрөгийн өвс тэжээл орлого авч, 161,936.8 мянган төгрөгийн өвч тэжээлийг зарлагадсан ба өвс тэжээлийн тайланг тусад нь гаргаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.1-т Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй:, 16.1.1 дэх "Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Өвсний тооцож дахин бодож тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

7. Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Сэгс цагаан богд заставд 10,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Старлинг жен 3 тоног төхөөрөмж худалдан авч өгсөн ба тухайн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй бөгөөд цаашид тухайн хөрөнгийн засвар үйлчилгээтэй асуудлыг хэн хариуцах талаар тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тус хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж тус хилийн заставтай хөрөнгө эзэмшүүлэх талаар гэрээ байгуулах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------oOo----------

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс багш эмч нарт 46,500.0 мянган төгрөгийн тэтгэмжийн зардлаас 4,650.0 мянган төгрөгийн ХАОАТ-ыг суутгаж олгосон ба 2,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна. | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | | | | |
| Анхан шатны баримтгүй 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",гэсэн заалтыг зөрчсөн байна. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | |
| Дурсамж принт ХХК руу 2024 оны 05 сарын 27 өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 2,645.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6 дах "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг зөрчсөн байна.. | 1 | 2,645.0 | | | 1 | 2,645.0 | | |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор хийгдсэн Залаагийн цагаан сувд ХХК нийлүүлсэн 28,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Баянбулаг омгийн 40 хуц, Залаажинст Эдрэн үүлдрийн 40 ухныг Шинэжинст сумын ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон комисс хүлээн авсан байхад сумын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийн заавал бүртгэнэ; 14.4.2 дахь "Бүх хөрөнгө,хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.. | 1 | 28,000.0 | | | 1 | 28,000.0 | | |
| Тусгай зориулалтын материалаас тушаал шийдвэр гараагүй байхад 36,216.7 мянган төгрөгийн хөрөнгө зарлагадсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх Тооллогын комисс дараах үүрэгтэйд 5) "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас | 1 | 36,216.7 | | | 1 | 36,216.7 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хасуулах тухай саналаа тавих." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.. | | | | | | | | |
| Тайлан оны санхүүгийн тайланд 129,809.8 мянган төгрөгийн өвс тэжээл орлого авч, 161,936.8 мянган төгрөгийн өвч тэжээлийг зарлагадсан ба нярвын тайлан байхгүй Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.1-т Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй:, 16.1.1 дэх "Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.. | 1 | 161,936.8 | | | 1 | 161,936.8 | | |
| Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Сэгс цагаан богд заставд 10,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Старлинг жен 3 тоног төхөөрөмж худалдан авч өгсөн ба тухайн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй бөгөөд цаашид тухайн хөрөнгийн засвар үйлчилгээтэй асуудлыг хэн хариуцах талаар тодорхойгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.. | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | |
| Сумын ЗДТГ-ын Ланд-200 автомашины урсгал засварын зардалд 2024.02.16-д иргэнд 17,000.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна<br>Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна. | 1 | 17,000.0 | | | 1 | 17,000.0 | | |
| 2024 оны 04 сарын 08-ны өдөр тээврийн хөлсөнд 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд Э баримтгүй хавсаргаагүй байна.<br>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугээр зүйлийн 17.6 дахь" Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна | | | | | | | | |
| Дүн | **9** | **259,798.5** | **2** | **3,000.0** | 7 | 256,798.5 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой | | | | | | | | |
| Сумын Засаг даргын 2024.12.18-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага хувцас бомборын зардалд 4,187.7 мянган төгрөгийг төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна. | 1 | 4,187.7 | 1 | 4,187.7 | | | | |
| Дүн | 1 | 4,187.7 | 1 | 4,187.7 | | | | |

----------oOo-----------